



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар ОХШ-2025/23

Сүхбаатар сум

Хүдэр сумын Засаг даргын Тамгын
Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн №СХШ-2025/14/-ТШЗ дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын Санхүү хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Мөнхзул 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын (цаашид Хүдэр сумын ЗДТГ гэх)-ын 2024, 2025 онуудын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Хүдэр сумын ЗДТГ нь улсын бүртгэлийн 9055339 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131355001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100131355408 дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5. Хүдэр сумын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ЗДТГ-ын дарга Г.Цэрэндамба, 2-р гарын үсгийг нягтлан бодогч П.Гантуяа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Хүдэр сумын ЗДТГ нь улс төрийн албан тушаалтан 4, төрийн захиргааны албан хаагч 10, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 11 нийт 25 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 86.7 хувь, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт 82.8 хувь, Сэлэнгэ аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 80.0 хувь хэрэгжүүлсэн байна.

2.1.2 Сумын ЗДТГ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хууль тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2024 онд 1,650,093.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,434,389.2 мянган төгрөгийг 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 1,671,032.6 мянган төгрөгөөр санхүүжихээр төсөв батлагдсанаас 1,401,593.6 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	2024 он			2025 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт -/-	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт -/-
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,650,093.3	1,434,389.2	215,704.1	1,671,032.6	1,401,593.6	269,439.0
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,650,093.3	1,434,389.2	215,704.1	1,671,032.6	1,401,593.6	269,439.0
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,605,434.4	1,406,435.2	198,999.2	1,626,752.2	1,361,001.6	265,750.6
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	941,928.3	812,249.4	129,678.9	810,414.8	716,520.2	93,894.6
5	Үндсэн цалин	477,934.6	425,643.9	52,290.7	405,854.9	386,686.4	19,168.5
6	Нэмэгдэл	406,294.8	352,801.3	53,493.5	323,807.9	304,552.8	19,255.1
7	Урамшуулал	57,698.9	33,804.2	23,894.8	80,752.0	25,281.0	55,471.0
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,350.0	110,156.9	9,193.1	101,114.1	89,415.9	11,698.2
9	Тэтгэврийн даатгал	81,158.0	74,700.2	6,457.8	68,903.9	60,643.1	8,260.8

10	Тэтгэмжийн даатгал	9,548.0	8,858.9	689.1	8,053.1	7,134.9	918.2
11	ҮОМШӨ-ний даатгал	4,774.0	4,601.3	172.7	4,026.2	3,856.0	170.2
12	Ажилгүйдлийн даатгал	4,774.0	4,401.1	372.9	4,026.2	3,556.6	469.6
13	Эрүүл мэндийн даатгал	19,096.0	17,595.4	1,500.6	16,104.7	14,225.3	1,879.4
14	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,468.2	62,166.6	1,301.6	61,521.5	48,298.3	13,223.3
15	Гэрэл, цахилгаан	10,120.0	9,263.6	856.4	10,524.5	7,604.6	2,919.9
16	Түлш, халаалт	47,547.8	47,105.8	442.0	36,947.2	36,346.5	600.7
17	Цэвэр, бохир ус	5,800.4	5,797.2	3.2	4,349.8	4,347.2	2.6
18	Байрны түрээс				9,700.0	-	9,700.0
19	Хангамж, бараа материалын зардал	43,371.5	42,459.2	912.3	48,921.3	37,681.4	11,239.9
20	Бичиг хэрэг	5,193.3	4,908.5	284.8	9,277.8	6,691.4	2,586.4
21	Тээвэр, шатахуун	26,084.9	26,077.2	7.7	22,251.6	19,353.0	2,898.6
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,943.3	2,256.8	686.5	3,709.4	1,350.9	2,358.5
23	Ном, хэвлэл	4,000.0	4,065.0	(65.0)	5,000.0	3,732.5	1,267.5
24	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	22.8	-	22.8	346.3	-	346.3
25	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,127.2	5,151.7	(24.5)	8,336.2	6,553.6	1,782.6
26	Нормативт зардал	620.6	500.0	120.6	3,065.6	519.9	2,545.7
27	Нормын хувцас, зөөлөн эдлэл	620.6	500.0	120.6	3,065.6	519.9	2,545.7
28	Эд хогшил, урсгал засварын зардал	80,869.9	79,827.6	1,042.3	78,343.7	33,923.6	44,420.1
29	Багаж, техник, хэрэгсэл	28,655.2	28,115.9	539.3	33,343.7	17,594.7	15,749.0
30	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	714.7	709.0	5.7			-
31	Урсгал засвар	51,500.0	51,002.7		45,000.0	16,328.9	28,671.1
32	Томилолт, зочны зардал	8,738.3	7,616.0	1,122.3	10,482.0	7,954.8	2,527.2
33	Дотоод албан томилолт	8,738.3	7,616.0	1,122.3	10,482.0	7,954.8	2,527.2
34	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,824.5	109,669.3	22,155.2	114,370.2	80,317.9	34,052.3

35	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	126,927.1	107,949.3	18,977.8	107,695.6	78,040.0	29,655.6
36	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	338.8	-	338.8	811.1	-	811.1
37	Даатгалын үйлчилгээ	964.9	258.6	706.4	942.0	310.0	632.0
38	Тээврийн хэрэгслийн татвар	610.3	436.4	173.9	1,607.8	838.5	769.3
39	Тээврийн хэрэгслийн оношлогоо	315.8	165.0	150.8	301.8	165.0	136.8
40	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000.4	685.0	315.4	1,019.7	-	1,019.7
41	Газрын төлбөр	2.8	-	2.8	906.3	-	906.3
42	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	233.4	-	233.4	54.2	-	54.2
43	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,431.0	175.0	1,256.0	1,031.7	964.5	67.2
44	Бараа үйлчилгээний бусад зардал	215,263.1	181,790.2	33,472.9	398,519.0	346,369.6	52,149.4
45	Бараа үйлчилгээний бусад зардал	214,237.7	181,330.2	32,907.5	396,826.7	346,289.6	50,537.1
46	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,025.4	460.0	565.4	1,692.3	80.0	1,612.3
47	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,658.9	27,954.0	16,705.0	44,280.4	40,592.1	3,688.4
48	Бусад урсгал шилжүүлэг	44,658.9	27,954.0	16,705.0	44,280.4	40,592.1	3,688.4
49	Хөдөө орон нутагт тогтвор суур	38,622.0	21,918.0	16,704.1			-
50	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,036.9	6,036.0	0.9	44,280.4	40,592.1	3,688.4
Б	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,650,093.3	1,434,389.2	215,704.1	1,671,032.6	1,401,593.6	269,439.0

2024 онд төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,434,389.2 мянган төгрөг буюу 86.9 хувьтай 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 1,401,593.6 мянган төгрөг нь 84.0 хувьтай зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн судалгаанаас зарцуулалтыг зардлын ангилал бүрээр шалгаж дүгнэхэд:

1. **Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** нийт төсвийн 2024 онд 941,928.3 мянган төгрөг 2025 онд 810,414.8 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгохоор төсөвлөснөөс 2024 онд 812,249.4 мянган төгрөгийг зарцуулж 129,678.9 мянган төгрөгийг хэмнэж 2025 оны 3

дугаар улирлын байдлаар 716,520.2 мянган төгрөгийг зарцуулж 93,894.6 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

2. **Хангамж бараа материалын зардал:** 2024 онд хангамж, бараа материалын зардалд 43,371.5 мянган төгрөг батлагдсанаас бичиг хэргийн зардалд 4,908.5 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 26,077.2 мянган төгрөг, шуудан, холбоо, интернетийн зардалд 2,256.8 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 4,065.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 5,151.7 мянган төгрөг зарцуулж 912.3 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2025 оны 3 улирлын байдлаар хангамж, бараа материалын зардалд 48,921.3 мянган төгрөг батлагдаж 37,681.4 мянган төгрөгийг зарцуулан 11,239.9 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.
3. **Томилолтын зардал:** 2024 онд 8,738.3 мянган төгрөг батлагдаж 87.2 хувь, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 10,482.0 мянган төгрөг батлагдаж 7,954.8 мянган төгрөгийг зарцуулж 2,527.2 мянган төгрөгийг хэмнэн ажиллаж байна.
4. **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2024 онд 131,824.5 мянган төгрөг батлагдсанаас 109,669.3 мянган төгрөг зарцуулж 22,155.2 мянган төгрөг хэмнэсэн, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 114,370.2 мянган төгрөг батлагдсанаас 80,317.9 мянган төгрөгийг зарцуулж 34,052.3 мянган төгрөгийг хэмнэж БГАҮ-ний зардалд тайлагнасан байна.
5. **Бараа үйлчилгээний бусад зардал:** 2024 онд 215,263.1 мянган төгрөг батлагдаж 181,790.2 мянган төгрөгийг зарцуулж 33,472.9 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 398,519.0 мянган төгрөг батлагдсанаас 346,369.6 мянган төгрөгийг зарцуулж 52,149.4 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.
6. **Урсгал шилжүүлгийн зардал:** 2024 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчийн тэтгэмжид 38,622.0 мянган төгрөг батлагдсанаас 21,918.0 мянган төгрөгийг зарцуулж 16,704.1 мянган төгрөгийн хэмнэлттэй, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 6,036.9 мянган төгрөг батлагдаж 6,036.0 мянган төгрөгийг зарцуулж 0.9 мянган төгрөгийг хэмнэсэн 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 44,280.4 мянган төгрөг батлагдсанаас 40,592.1 мянган төгрөгийг зарцуулж 3,688.4 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд: 2024 онд тус сумын ЗДТГ-ийн нэмэлт санхүүжилтийн 100131355408 дугаар дансанд аймгийн ЗДНХ-аас 13,394.8 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 1,098.1 мянган төгрөг, БТСГ-аас 800.0 мянган төгрөгийн бүх нийтийн гүйлтийн арга хэмжээний зардал, үндсэн үйл ажиллагааны орлогоос 13,800.0 мянган төгрөг зэрэг нийт 29,092.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна. 2025 оны 3 улирлын байдлаар статистикаас 1,160.0 төгрөг, түймэр хандив 15,250.0 мянган төгрөг, байгаль орчин дэнчин 1,622,704.8 мянган төгрөгийн нийт 1,678,501.8 мянган төгрөгийн орлогыг зарцуулсан байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024,2025 онуудад сумын ЗДТГ-ын цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

Сумын ЗДТГазар нь 25 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын батлагдсан төсвөөс 2024 онд 812,249.4 мянган төгрөг буюу 86.2 хувь, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 716,520.2 мянган төгрөг буюу 88.4 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд олгосон байна.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2025 оны нийт цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллын зардал өмнөх оноос нэмэгдсэн байна.

2.4 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн боловч үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтлөхгүй байгаа нь санхүүгийн тайлан, мэдээлэл буруу илэрхийлэгдэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна. Иймд дээрх бүртгэлийн алдааг залруулж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Хүдэр сумын ЗДТГ-ын 2024, 2025 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, цалин хөлсний тооцоолол, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй зэрэг дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1. Бараа үйлчилгээний бусад зардлаас албан хаагчийн сургалтын төлбөрийн зардалд 1,755.5 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн татварын зардлаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 200.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлагыг хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тээврийн хэрэгслэлийн 100 км гүйлтэд зарцуулах норм баримтлаагүй жолоочийн тооцооны хуудасны маягтанд явсан заалтыг бичихгүй дутуу бөглөж ажилд гарсан тухай бүрт нь хөтлүүлээгүй 2024 онд 18,056.9 мянган төгрөгийн шатахуун олгож зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг, Зам тээврийн хөгжлийн сайдын “Жишиг норм батлах тухай” 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм” нэгдүгээр хавсралт дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудсыг ажилд гарсан тухай бүрд нь километрийн заалтыг бичүүлж шатахууныг сар бүр тооцож тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 14,161.0 мянган төгрөгөөр тооцох хугацааг дутуу оруулж элэгдлийг буруу тооцоолсон байна. Үндсэн хөрөнгийн дансны ангилал болон хөрөнгийн нэршлийг ерөнхий утгаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “Үнэн зөв байх”, 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.: 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам”-ын 2, дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцох хугацааг бодлогын бичиг баримтад заасны дагуу дахин тооцоолж бүртгэл тайланд залруулж тусгах зөвлөмж хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Хүдэр сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн

эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Хүдэр сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 34,173.4 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох 1,955.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, давтан гаргахгүй 32,217.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮ ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН.

ХҮДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА



Г.ЦЭРЭНДАМБА

НЯГТЛАН БОДОГЧ

П.ГАНТУЯА